



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

┌
Зонхилон тохиолдох гэдэсний халдварт
өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай
└

Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ, авах журам” А/328 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай” А/527 дугаар тушаал, “Зонхилон тохиолдох гэдэсний бактерит халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний заавар” А/528 дугаар тушаал, НЭМГ-ын даргын А/82 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Харьяа ӨЭМТ-ийн дарга, тасгийн эрхлэгч нарт даалгах нь:
 - 1.1 Гэдэсний халдварт өвчнийг оношлох, эмчлэх, хянах, голомтын хариу арга хэмжээг авах, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах,
 - 1.2 Харьяа дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хүүхдийн байгууллагын багш ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаж байгаа эсэхэд тогтмол судалгааг хийж, шинжилгээний үнэн зөв байдалд хяналт тавих,
 - 1.3 Эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний тандах тогтолцоогоор мэдээлж буй гэдэсний халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдолд дүн шинжилгээг хийж, урьдчилан сэргийлэх болон голомтын хариу арга хэмжээг боловсролын болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллах,
 - 1.4 Харьяа дүүргийн хүүхдийн байгууллагад гэдэсний халдвараас сэргийлэх болон гараа зөв угаах сургалт сурталчилгааг тогтмол хийх, гарын саван, халдваргүйжүүлэх бодис, уусмалын хэрэглээг тогтмолжуулж хэвшүүлэх, хангах талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллах,
 - 1.5 Гэдэсний халдвараас сэргийлэх талаар иргэд, эцэг эхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, өдөрлөг, уулзалтыг тогтмол зохион байгуулах, мэдээллээр хангах,
 - 1.6 Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаарх мэдээллийг баримтжуулан тус төвийн тархвар судлаач /Б.Цэндсүрэн/-д tsendsurenbb@gmail.com цахим хаягаар 7, 9, 11-р сарын 25-ны өдрийн дотор илгээх,

30170 70 0502

2. Зонхилон тохиолдох гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг тархвар судлаач /Б.Цэндсүрэн/, иргэдэд чиглэсэн зөвлөмж, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг сургалт хариуцсан мэргэжилтэн /Ч.Гүнчинхорлоо/ нарт үүрэг болгосугай,
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГА



Э. БОДЬЦЭЦЭГ